



ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ШАРЫН ГОЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН  
ГАЗРЫН 2024 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД  
ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: ДАА-2025/7/НА-СТА-ТШЗ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг  
дараах хаягаар авна уу.



**Дарга, тэргүүлэх аудитор Ш.Мөнхбаяр**

Утас: 70373089 Цахим хаяг: munkhbayarsh@audit.gov.mn

**Аудитын менежер У.Батсүрэн**

Утас: 70373089 Цахим хаяг: batsurenu@audit.gov.mn

**Ахлах аудитор С.Батцэцэг**

Утас: 70373089 Цахим хаяг: battsetsegs@audit.gov.mn

**Аудитор Д.Ариунзаяа**

Утас: 70373089 Цахим хаяг: AriunzayaD@audit.gov.mn

<b>1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ</b> .....	2
<b>Асуудлыг онцолсон хэсэг</b> .....	2
<b>2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ</b> .....	4
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	13
<b>3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА</b> .....	14
<b>4. АУДИТЫН ТАЙЛАН</b> .....	17
<b>4.1 Ерөнхий зүйл</b> .....	17
<b>4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал</b> .....	17
<b>4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт</b> .....	18
<b>4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт</b> .....	18
<b>4.5.1 Завсрын аудитын талаар</b> .....	18
<b>4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал</b> .....	18
<b>5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ</b> .....	18
<b>5.1 Төлбөрийн акт</b> .....	19
<b>5.2 Албан шаардлага</b> .....	19
<b>5.3 Зөвлөмж</b> .....	19
<b>6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ</b> .....	20

**Товчилсон үгийн жагсаалт**

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
БОАЖГ	Байгаль орчин, аялал жуулчлалын газар
БГАҮТХ	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж
ЗГНХ,ЗДНХөрөнгө	Засгийн газрын нөөц хөрөнгө, Засаг даргын нөөц хөрөнгө
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн хурал
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт



**ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Бурхантын гудамж-1, 14 дүгээр баг, Дархан сум,  
Дархан-Уул аймаг, 45059,  
Утас: 7037-3089, Факс: (976) 7037-3089  
Цахим шуудан: darkhanuul@audit.gov.mn  
Цахим хуудас: www.audit.mn

2025.02.14 № 33

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**ШАРЫН ГОЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА  
Г.ШИНЭХҮҮ ТАНАА**

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Шарын гол сумын Засаг даргын тамгын газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Шарын гол сумын Засаг даргын тамгын газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Тайлант онд ОНХС-н хөрөнгөөр бий болсон 910,072.4 мянган төгрөгийн хөрөнгө, Онцгой байдлын газраас шилжүүлсэн 106,900.0 мянган төгрөгийн Сузуки жимни загварын автомашиныг үнэ төлбөргүйгээр бүртгэж, санхүүгийн тайланд толилуулж тодруулсан байна.

**Аудитын гол асуудал**

Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 128 дугаар тогтоолоор төрийн албан хаагчдын цалингийн хэмжээ нэмэгдүүлж, 171 дүгээр тогтоолоор улс төрийн албан хаагчид орон нутгийн нэмэгдэл олгож эхэлснээр цалингийн зардал өнгөрсөн оны гүйцэтгэлээс 16.1 хувиар өссөн байна. Мөн Засгийн газрын 83 дугаар тогтоолоор төрийн захиргааны албан хаагчдад 5 жил тутам мөнгөн урамшуулал олгож эхэлснээр 4 албан хаагчдад 128,003.4 мянган төгрөгийн тэтгэмж, урамшуулал олгосон байна.

**Бусад асуудлын хэсэг**

452501031

Төсвийн шууд захирагч бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Шарын гол сумын Засаг даргын тамгын газар нь 2024 онд 6 зорилт 32 арга хэмжээ төлөвлөж, хэрэгжилтийг 92.6 хувиар тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ш.МӨНХБАЯР

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>205,227,663.32</u></b>	<b><u>341,238,263.32</u></b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	-	-
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	1,030,000.00	10,000,000.00
33300	Татаас, санхүүжилтийн авлага	1,030,000.00	-
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	-	10,000,000.00
3351	Байгууллагаас авах авлага	-	10,000,000.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	161,040,153.32	285,637,253.32
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	1,949,850.00	2,463,850.00
35110	Тусгай зориулалттай материал	-	450,000.00
35130	Эм боох материал	1,949,850.00	2,013,850.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	159,090,303.32	283,173,403.32
35410	Бичиг хэргийн материал	43,055,663.00	147,978,963.00
35420	Аж ахуйн материал	98,707,290.32	114,092,090.32
35430	Сэлбэг хэрэгсэл	-	2,300,000.00
35440	Түлш, шатах тослох материал	1,262,850.00	1,262,850.00
35450	Барилгын засварын материал	1,396,000.00	1,561,000.00
35470	Бусад хангамжийн материал	14,668,500.00	15,978,500.00
<b>36</b>	<b>НӨӨЦИЙН БАРАА</b>	43,157,510.00	45,601,010.00
36300	Тэжээлийн нөөц	42,834,000.00	20,277,500.00
36400	Шатахууны нөөц	323,510.00	323,510.00
36600	Бусад нөөц	-	25,000,000.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>3,154,755,299.40</u></b>	<b><u>4,241,400,545.56</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	3,154,755,299.40	4,241,400,545.56
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	3,150,337,299.40	3,819,938,245.56
39201	Барилга, байгууламж, орон сууц	909,777,813.83	909,777,813.83
39202	Хуримтлагдсан элэгдэл	(135,149,263.08)	(163,427,186.28)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	227,984,800.00	288,934,800.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(195,165,355.24)	(163,596,084.44)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	124,919,340.00	146,118,527.50
39206	Хуримтлагдсан элэгдэл	(54,580,151.98)	(52,690,037.52)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	44,267,700.00	58,410,390.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(26,312,628.06)	(17,639,277.78)
39209	Зам, гүүрийн байгууламж	836,682,819.40	836,682,819.40
39210	Хуримтлагдсан элэгдэл	(553,017,473.90)	(598,974,563.68)
39214	Бусад үндсэн хөрөнгө	2,859,859,775.28	3,769,932,195.88
39215	Хуримтлагдсан элэгдэл	(969,806,415.85)	(1,274,467,043.35)
39216	Дуусаагүй барилга, байгууламж	79,468,039.00	79,468,039.00
39217	Ном	1,408,300.00	1,408,300.00

<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	4,418,000.00	421,462,300.00
39301	Програм хангамж	2,174,300.00	2,174,300.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(2,174,300.00)	(2,174,300.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	4,418,000.00	421,462,300.00
39304	Хуримтлагдсан элэгдэл		
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>3,359,982,962.72</u></b>	<b><u>4,582,638,808.88</u></b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b><u>1,030,000.00</u></b>	<b>-</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	1,030,000.00	-
<b>413</b>	<b>Өглөг</b>	1,030,000.00	-
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	840,000.00	-
<b>4136</b>	<b>Бусад өглөг</b>	190,000.00	-
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	190,000.00	-
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>3,358,952,962.72</u></b>	<b><u>4,582,638,808.88</u></b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	3,358,952,962.72	4,582,638,808.88
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	973,019,783.54	973,019,783.54
51101	Өмч: - төрийн	973,019,783.54	973,019,783.54
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	1,546,080,621.02	2,769,766,467.18
51210	Өмнөх үеийн үр дүн	1,546,080,621.02	1,546,080,621.02
51220	Тайлант үеийн үр дүн	-	1,223,685,846.16
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	839,852,558.16	839,852,558.16
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b><u>3,359,982,962.72</u></b>	<b><u>4,582,638,808.88</u></b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/			
Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>1,740,758,617.00</b>	<b>3,382,793,578.10</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>724,895,117.00</b>	<b>1,654,995,258.10</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	724,895,117.00	<b>1,654,995,258.10</b>
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	724,895,117.00	<b>1,654,995,258.10</b>
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	-
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	32,685,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	-	113,446,258.50
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	724,895,117.00	1,478,815,699.60
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал		30,048,300.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,015,863,500.00</b>	<b>1,727,798,320.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	34,131,800.00	<b>11,978,020.00</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	10,930,600.00	10,928,020.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	23,201,200.00	1,050,000.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	981,731,700.00	1,715,820,300.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	981,731,700.00	1,715,820,300.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>1,404,505,118.17</b>	<b>2,128,932,731.94</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,404,505,118.17</b>	<b>2,128,932,731.94</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	1,392,521,897.25	2,035,130,157.83
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	657,845,969.83	1,062,472,419.56
210101	Үндсэн цалин	462,813,979.44	592,784,805.78
210102	Нэмэгдэл	130,588,996.73	358,306,399.31
210103	Унаа хоолны хөнгөлөлт	21,037,973.27	22,828,404.95
210104	Урамшуулал	43,405,020.39	75,850,960.83
210105	Гэрээт ажлын хөлс	-	12,611,848.69
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	82,497,757.64	132,663,328.61
210201	Тэтгэврийн даатгал	58,251,386.25	90,805,195.05
210202	Тэтгэмжийн даатгал	6,826,930.41	10,942,647.25
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,329,544.42	8,326,407.05
210204	Ажилгүйдлийн даатгал	1,099,081.53	4,517,775.05
210205	Эрүүл мэндийн даатгал	10,990,815.03	18,071,304.21
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	70,707,920.56	83,367,115.86
210301	Гэрэл, цахилгаан	24,164,183.03	36,800,186.27
210302	Түлш, халаалт	41,298,635.76	42,690,615.10
210303	Цэвэр, бохир ус	2,545,101.77	4,076,314.49
210304	Байрны түрээс	2,700,000.00	-
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	72,886,773.45	55,318,396.65
210401	Бичиг хэрэг	8,274,850.00	7,859,000.00
210402	Тээвэр, шатахуун	51,285,203.40	39,779,955.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,447,625.05	5,850,101.65
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	7,879,095.00	1,220,340.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	16,511,070.00	41,873,951.21
210604	Урсгал засвар	16,511,070.00	41,873,951.21
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	2,726,000.00	6,194,000.00
210702	Дотоод албан томилолт	2,726,000.00	6,194,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	18,270,080.00	106,703,524.00

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	15,464,533.00	104,425,002.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	-
210803	Даатгалын үйлчилгээ	469,400.00	365,670.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	365,000.00	302,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	220,000.00	165,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	516,000.00	516,000.00
210807	Газрын төлбөр	1,235,147.00	929,852.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>471,076,325.77</b>	<b>546,337,421.94</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	49,364,437.50	113,090,910.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	800,000.00	3,450,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	420,911,888.27	429,846,511.94
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>11,983,220.92</b>	<b>93,752,574.11</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>2,991,600.00</b>	<b>65,975,332.50</b>
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	1,531,600.00	240,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	31,067,864.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	-	28,003,468.50
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,460,000.00	6,664,000.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>8,991,620.92</b>	<b>27,777,241.61</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	8,991,620.92	27,777,241.61
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>336,253,498.83</b>	<b>1,253,860,846.16</b>
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>-</b>	<b>30,175,000.00</b>
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	-	30,175,000.00
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	<b>-</b>	<b>(30,175,000.00)</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>336,253,498.83</b>	<b>1,223,685,846.16</b>

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/			
Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>1,026,957,765.80</b>	<b>1,761,513,320.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	-	<b>32,685,000.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	-	<b>32,685,000.00</b>
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	-	32,685,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	32,685,000.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,026,957,765.80</b>	<b>1,728,828,320.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	45,226,065.80	<b>13,008,020.00</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	10,930,600.00	10,926,020.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	34,295,465.80	2,080,000.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	981,731,700.00	1,715,820,300.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	981,731,700.00	1,715,820,300.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>999,124,065.80</b>	<b>1,721,253,520.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>999,124,065.80</b>	<b>1,721,253,520.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>986,110,844.88</b>	<b>1,627,600,945.89</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	657,845,969.83	1,062,472,419.56
210101	Үндсэн цалин	462,813,979.44	592,784,605.78
210102	Нэмэгдэл	130,588,996.73	358,395,399.31
210103	Унаа хоолны хөнгөлөлт	21,037,973.27	22,828,404.95
210104	Урамшуулал	43,405,020.39	75,850,960.83
210105	Гэрээт ажлын хөлс	-	12,611,848.69
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	82,295,788.54	132,663,323.61
210201	Тэтгэврийн даатгал	58,049,417.15	90,806,195.05
210202	Тэтгэмжийн даатгал	6,826,930.41	10,942,647.25
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,329,544.42	8,326,407.05
210204	Ажилгүйдлийн даатгал	1,099,081.53	4,517,775.05
210205	Эрүүл мэндийн даатгал	10,990,815.03	18,071,304.21
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	70,655,920.56	83,367,115.86
210301	Гэрэл, цахилгаан	24,164,183.03	36,800,186.27
210302	Түлш, халаалт	41,246,635.76	42,690,615.10
210303	Цэвэр, бохир ус	2,545,101.77	4,076,314.49
210304	Байрны түрээс	2,700,000.00	-
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	44,904,391.45	46,902,800.00
210401	Бичиг хэрэг	7,305,600.00	7,358,000.00
210402	Тээвэр, шатахуун	30,720,563.40	31,364,358.35
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,447,625.05	5,850,101.65
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,430,603.00	1,829,340.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	-	340,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	340,000.00

<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	22,606,370.00	39,069,500.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	3,960,000.00	1,650,000.00
210602	Тавилга	-	2,560,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1,003,000.00	-
210604	Урсгал засвар	17,643,370.00	34,859,500.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	2,726,000.00	6,194,000.00
210702	Дотоод албан томилолт	2,726,000.00	6,194,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	31,926,877.00	113,099,754.86
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	29,014,372.00	110,821,232.86
210803	Даатгалын үйлчилгээ	469,400.00	365,670.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	471,958.00	302,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	220,000.00	165,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	516,000.00	516,000.00
210807	Газрын төлбөр	1,235,147.00	929,852.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	73,149,527.50	143,192,027.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	72,549,527.50	139,742,027.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	600,000.00	3,450,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>13,013,220.92</b>	<b>93,752,574.11</b>
<b>2131</b>	<b>Засгийн газрын урсгал шилжүүлэг</b>	-	-
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	2,991,600.00	65,975,332.50
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	1,501,600.00	240,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	31,067,864.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	-	28,000,468.50
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,490,000.00	6,664,000.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	10,021,620.92	27,777,241.61
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	10,021,620.92	27,777,241.61
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>27,833,700.00</b>	<b>40,259,800.00</b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>27,833,700.00</b>	<b>40,259,800.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>27,833,700.00</b>	<b>40,259,800.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	27,833,700.00	40,259,800.00
222001	Тоног төхөөрөмж	27,833,700.00	20,319,800.00
223001	Бусад хөрөнгө	-	19,940,000.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b>(27,833,700.00)</b>	<b>(40,259,800.00)</b>
	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>7</b>	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	=	=
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	0.00	0.00
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	-	-
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	-	-

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	973,019,783.54	839,852,558.16	1,209,827,122.19	-	3,022,699,463.89
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-	-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	973,019,783.54	839,852,558.16	1,209,827,122.19	-	3,022,699,463.89
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-	-	-
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-	-	-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-	-
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	336,253,498.83	-	336,253,498.83
C08	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	973,019,783.54	839,852,558.16	1,546,080,621.02	-	3,358,952,962.72
D01	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	973,019,783.54	839,852,558.16	1,546,080,621.02	-	3,358,952,962.72
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-	-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	973,019,783.54	839,852,558.16	1,546,080,621.02	-	3,358,952,962.72
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-	-
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-	-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-	-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-	-
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	1,223,685,846.16	-	1,223,685,846.16
D09	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	973,019,783.54	839,852,558.16	2,769,766,467.18	-	4,582,638,808.88

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны			
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>1,880,045,500.00</b>	<b>1,720,759,178.39</b>	<b>(159,286,321.61)</b>	<b>91.53</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,880,045,500.00</b>	<b>1,720,759,178.39</b>	<b>(159,286,321.61)</b>	<b>91.53</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,804,395,600.00</b>	<b>1,655,103,845.89</b>	<b>(149,291,754.11)</b>	<b>91.73</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>1,156,435,400.00</b>	<b>1,062,472,419.56</b>	<b>(93,962,980.44)</b>	<b>91.87</b>
210101	Үндсэн цалин	584,211,900.00	592,784,805.78	8,572,905.78	101.47
210102	Нэмэгдэл	461,848,500.00	358,396,399.31	(103,452,100.69)	77.60
210103	Унаа хоолны хөнгөлөлт	27,950,700.00	22,828,404.95	(5,122,295.05)	81.67
210104	Урамшуулал	69,735,800.00	75,850,960.83	6,115,160.83	108.77
210105	Гэрээт ажлын хөлс	12,688,500.00	12,611,848.69	(76,651.31)	99.40
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>148,238,900.00</b>	<b>132,663,328.61</b>	<b>(15,575,571.39)</b>	<b>89.49</b>
210201	Тэтгэврийн даатгал	101,981,400.00	90,805,195.05	(11,176,204.95)	89.04
210202	Тэтгэмжийн даатгал	11,564,400.00	10,942,647.25	(621,752.75)	94.62
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,782,200.00	8,326,407.05	2,544,207.05	144.00
210204	Ажилгүйдлийн даатгал	5,782,200.00	4,517,775.05	(1,264,424.95)	78.13
210205	Эрүүл мэндийн даатгал	23,128,700.00	18,071,304.21	(5,057,395.79)	78.13
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>99,806,900.00</b>	<b>83,567,115.86</b>	<b>(16,239,784.14)</b>	<b>83.73</b>
210301	Гэрэл, цахилгаан	18,440,100.00	36,800,186.27	18,360,086.27	199.57
210302	Түлш, халаалт	73,880,600.00	42,690,615.10	(31,189,984.90)	57.78
210303	Цэвэр, бохир ус	7,486,200.00	4,076,314.49	(3,409,885.51)	54.45
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>44,245,900.00</b>	<b>44,245,900.00</b>	<b>-</b>	<b>100.00</b>
210401	Бичиг хэрэг	5,000,000.00	6,619,000.00	1,619,000.00	132.38
210402	Тээвэр, шатахуун	32,079,200.00	29,947,458.35	(2,131,741.65)	93.35
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,516,700.00	5,850,101.65	333,401.65	106.04
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,650,000.00	1,829,340.00	179,340.00	110.87
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>3,300,000.00</b>	<b>340,000.00</b>	<b>(2,960,000.00)</b>	<b>10.30</b>
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,300,000.00	340,000.00	(2,960,000.00)	10.30
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>67,159,500.00</b>	<b>66,829,300.00</b>	<b>(330,200.00)</b>	<b>99.51</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	15,700,000.00	15,369,800.00	(330,200.00)	97.90
210602	Тавилга	20,000,000.00	20,000,000.00	-	100.00
210604	Урсгал засвар	31,459,500.00	31,459,500.00	-	100.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>6,612,000.00</b>	<b>6,194,000.00</b>	<b>(418,000.00)</b>	<b>93.68</b>
210702	Дотоод албан томилолт	6,612,000.00	6,194,000.00	(418,000.00)	93.68

2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>131,809,800.00</b>	<b>113,099,754.86</b>	<b>(18,710,045.14)</b>	<b>85.81</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	126,150,000.00	110,821,232.86	(15,328,767.14)	87.85
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,008,000.00	-	1,008,000.00	0.00
210803	Даатгалын үйлчилгээ	1,224,300.00	365,670.00	(858,630.00)	29.87
210804	Тээврийн хэрэгслийн татвар	589,000.00	302,000.00	(287,000.00)	51.27
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	231,000.00	165,000.00	(66,000.00)	71.43
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	607,500.00	516,000.00	(91,500.00)	84.94
210807	Газрын төлбөр	2,000,000.00	929,852.00	(1,070,148.00)	46.49
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>146,787,200.00</b>	<b>145,692,027.00</b>	<b>(1,095,173.00)</b>	<b>99.25</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	143,213,200.00	142,242,027.00	(971,173.00)	99.32
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,574,000.00	3,450,000.00	(124,000.00)	96.53
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>75,649,900.00</b>	<b>65,655,332.50</b>	<b>(9,994,567.50)</b>	<b>86.79</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>75,649,900.00</b>	<b>65,655,332.50</b>	<b>(9,994,567.50)</b>	<b>86.79</b>
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	1,500,000.00	240,000.00	(1,260,000.00)	16.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	31,067,900.00	31,067,864.00	(36.00)	100.00
213208	Хөдөө орон нутаг тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	36,582,000.00	28,003,468.50	(8,578,531.50)	76.55
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	6,500,000.00	6,344,000.00	(156,000.00)	97.60
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>1,880,045,500.00</b>	<b>1,721,030,778.39</b>	<b>(159,014,721.61)</b>	<b>91.54</b>
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>1,847,632,100.00</b>	<b>1,688,345,778.39</b>	<b>(159,286,321.61)</b>	<b>91.38</b>
132001	Орон нутгийн төсвөөс	1,847,632,100.00	1,688,345,778.39	(159,286,321.61)	91.38
<b>120004</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	<b>32,413,400.00</b>	<b>32,685,000.00</b>	<b>271,600.00</b>	<b>100.8</b>
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	32,413,400.00	32,685,000.00	271,600.00	100.8
<b>61</b>	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	<b>1.00</b>	<b>1.00</b>	<b>-</b>	<b>100.00</b>

ХТӨЗ439.С 5922859

610001	Төсвийн байгууллага	1.00	1.00	-	100.00
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСДЫН ТОО</b>	<b>46.00</b>	<b>42.00</b>	-	<b>91.30</b>
620001	Удирдах ажилтан	6.00	6.00	-	100.00
620002	Гүйцэтгэх ажилтан	22.00	18.00	-	81.82
620003	Үйлчлэх ажилтан	17.00	17.00	-	100.00
620004	Гэрээт ажилтан	1.00	1.00	-	100.00
<b>65</b>	<b>ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ</b>	<b>46.00</b>	<b>44.00</b>	-	<b>95.65</b>
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	18.00	15.00	-	83.33
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	22.00	23.00	-	104.55
650010	Гэрээт ажилтан	1.00	1.00	-	100.00
650011	Улс төрийн албан хаагч (УТ)	5.00	5.00	-	100.00

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>13,008,020.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>13,008,020.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	13,008,020.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	2,656,900.00
210401	Бичиг хэрэг	1,240,000.00
210402	Тээвэр, шатахуун	1,416,900.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	10,000,000.00
210604	Урсгал засвар	10,000,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	320,000.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	320,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	320,000.00
<b>2133</b>	<b>Олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>31,320.00</b>
213503	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг	31,320.00
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>13,008,020.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>13,008,020.00</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	10,928,020.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	2,080,000.00
<b>IV</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)</b>	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	..
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	..

### **3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА**

#### **3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа**

Шарын гол сумын Засаг даргын тамгын газар нь харьяалах нутаг дэвсгэрийнхээ эдийн засаг, нийгмийн хөгжлийн стратегийн төлөвлөлт, хөтөлбөр, төсөл зохиох, зохицуулах, хяналт шинжилгээ хийх, үнэлж дүгнэх бодлогын удирдамжаар хангах, Засаг даргаас бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд нь зохион байгуулалт, эрх зүй, аж ахуйн талаар болон Тамгын газрын тасаг албадын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, нутгийн захиргааны байгууллагыг чиглүүлэн удирдахад нь Засаг даргад туслах, Хурал, Засаг дарга, доод шатны удирдлагыг мэдээллээр хангах чиг үүргийг хэрэгжүүлдэг байгууллага юм.

Дархан-Уул аймгийн Шарын гол сумын Засаг даргын тамгын газар нь төрөөс иргэдэд үзүүлэх үйлчилгээг үр өгөөжтэй, хөнгөн шуурхай болгож төрийн албаны нэр хүндийг өндөрт өргөж, сахилга хариуцлагыг бүх шатанд дээшлүүлж, жижиг дунд үйлдвэрлэл үйлчилгээ өсөн нэмэгдэж, тогтворжсон эдийн засгийн чадавхтай, иргэдийн амар тайван ажиллаж амьдрах таатай орчин нөхцөлийг бүрдүүлэх зорилгыг дэвшүүлэн ажиллаж байна.

#### **3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин**

Тус байгууллага нь Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар баталсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зэрцүүлэлтийн нийтлэг журам” зэргийг үйл ажиллагаандаа мөрдөж байна.

Тайлант хугацаанд Төрийн албаны тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль зэрэг үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт орсон байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтыг төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг үр нөлөөтэй гэж тодорхойлсон, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэх шаардлагагүй гэж үзсэн.

#### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Шарын гол сумын Засаг даргын тамгын газрын 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

#### **3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд**

Шарын гол сумын Засаг даргын тамгын газрын 2024 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1,222,655.8 мянган төгрөгөөр буюу 36.3 хувиар өссөн байна.

*Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт*

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	1,030.0	10,000.0	8,970.0
Бараа материал	161,040.1	285,637.2	124,597.1
Нөөцийн бараа	43,157.5	45,601.0	2,443.5
Үндсэн хөрөнгө	3,154,755.3	4,241,400.5	1,086,645.2
<b>Нийт хөрөнгө</b>	<b>3,359,982.9</b>	<b>4,582,638.8</b>	<b>1,222,655.8</b>
Өр төлбөр	1,030.0	-	-
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	3,358,952.9	4,582,638.8	1,222,655.8
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>3,359,982.9</b>	<b>4,582,638.8</b>	<b>1,222,655.8</b>

Авлагын дансны эхний үлдэгдлийг барагдуулсан бөгөөд аудитын явцад анхан шатны баримтын бүрдэл болон ажлын гүйцэтгэл дутуу 10,000.0 мянган төгрөгийн урсгал засварын зардлыг авлагаар тусгуулсан.

Бараа материал дансны хувьд тайлант онд төсвийн хөрөнгөөр 163,563.1 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, урсгал үйл ажиллагаанд 144,340.0 мянган төгрөгийн бараа материал зарцуулснаар 124,597.1 мянган төгрөгөөр өссөн байна.

Нөөцийн барааны үлдэгдэл 2,443.5 мянган төгрөгөөр өссөн нь 42,600.0 мянган төгрөгөөр тэжээлийн хивэг, өвс худалдан авч, тайлант онд 40,156.5.0 мянган төгрөгийн өвс, тэжээл зарцуулснаас шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 1,086,645.2 мянган төгрөгөөр өссөн нь Онцгой байдлын газраас 106,900.0 мянган төгрөгийн автомашин, Шарын гол сумын ИТХ-ын 11 дүгээр тогтоолоор 910,072.4 мянган төгрөгийн хөрөнгө, нийгмийн хариуцлагын хүрээнд хийгдсэн ажлын 2,210.0 мянган төгрөгийн хөрөнгийг тус тус орлогод авч, тайлант онд 429,846.5 мянган төгрөгийн элэгдэл байгуулсан зэргээс шалтгаалсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,222,655.8 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд үнэ төлбөргүй хөрөнгө орлогод бүртгэснээс шалтгаалж өссөн тайлант үеийн үр дүнтэй холбоотой байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Төсвийн шууд захирагч 2024 оны төсвийн төсөлд нийт зарлагыг 1,441,983.8 мянган төгрөгөөр тооцож, санхүүжих эх үүсвэрийг орон нутгийн төсвөөс бүрдүүлэхээр төлөвлөн дээд шатны төсвийн захирагчид хүргүүлжээ.

Дээд шатны төсвийн захирагч төсвийн саналыг цалин, хөлсний өсөлттэй холбоотойгоор 268,697.8 мянган төгрөг нэмэгдүүлж, 1,710,681.6 мянган төгрөгөөр баталсныг тайлант оны 11 дүгээр сард цалин хөлс болон суутгалуудын хувь хэмжээ, бараа материалын үнэ өссөнтэй холбоотойгоор 1,880,045.5 мянган төгрөгөөр тодотгосон байна.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 11 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,847,632.1 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс, 32,413.4 мянган төгрөгийн төсөвт байгууллагын өөрийн орлогоор санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 1,715,820.3 мянган төгрөгийн санхүүжилт, төсөвт байгууллагын өөрийн орлогоос 32,685.0 мянган төгрөг тус тус төвлөрч, гүйцэтгэлээр 1,720,759.1 мянган төгрөг зарцуулж, санхүүжилтээс зарцуулаагүй 27,474.5 мянган төгрөг, давсан орлого 271.6 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,720,759.1 мянган төгрөг буюу 91.5 хувьтай байгаа нь багийн нийгмийн ажилтны орон тоо дутуу ажилласантай холбоотой байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

Д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/мянган төгрөгөөр/	
				Зөрүү	Хувь
1	<b>70106-Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага</b>	<b>1,880,045.5</b>	<b>1,720,759.1</b>	<b>(159,286.4)</b>	<b>91.5</b>
1.1	80101- Үндсэн үйл ажиллагааны зардал	907,930.3	856,979.5	(50,950.8)	94.4
1.2	80106-Баг хорооны үйл ажиллагааны зардал	366,706.6	290,271.5	(76,435.1)	79.2
1.3	80111-Төрийн өмчийн барилгын тогтмол зардал	114,806.9	102,145.5	(12,661.4)	90.0
1.4	80205-Мэдээлэл сурталчилгааны зардал	6,000.0	4,285.0	(1,715.0)	71.4
1.5	80233-Хүүхэд хамгаалал	24,000.0	20,549.1	(3,450.9)	86.0
1.6	80802-Ажил олгогчоос олгох, тэтгэмж урамшуулал	75,649.9	65,655.3	(9,994.6)	87.0
1.7	81102-Орон нутгийн нөөц хөрөнгө	78,835.0	78,262.7	(572.3)	99.2
1.8	81518-Мөрийн хөтөлбөрт тусгагдсан арга хэмжээ	10,000.0	9,645.2	(354.8)	96.4
1.9	81549-Ахмадын сан	3,500.0	3,500.0	-	100.0
1.10	82212-Хур хог хаягдал, орчны бохирдол	282,616.8	279,465.3	(3,151.5)	98.8
1.11	82801-Улсын их баяр наадам	10,000.0	10,000.0	-	100.0

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

Тус байгууллагын бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардалд баг хорооны үйл ажиллагааны зардал, хүүхэд хамгаалал, мэдээлэл сурталчилгааны зардал, хур хог хаягдал орчны бохирдлыг устгах, цэвэрлэх үйлчилгээний зардалд 110,222.6 мянган төгрөг зарцуулсан байна. Харин бараа үйлчилгээний бусад зардалд нийт 140,542.0 мянган төгрөгийг үндсэн үйл ажиллагааны зардал, орон нутгийн нөөц хөрөнгө, мөрийн хөтөлбөрт тусгагдсан зарим арга хэмжээг хэрэгжүүлэх, ахмадын сан, улсын их баяр наадмын зардалд зарцуулсан байна. Шарын гол сумын Засаг даргын тамгын газрын даргын А/01 дугаар тушаалаар 45 орон тоог баримталж ажилласан байна.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд тэргүүний шилдэг сумын урамшуулал 10,000.0 мянган төгрөг, тендерийн орлого 1,120.0 мянган төгрөг, хагас жилийн мал тооллого 728.0 мянган төгрөг, БОАЖГ-аас ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, хяналт тавих шатахууны зардал 200.0 мянган төгрөг, түрээсийн орлого 5,443.2 мянган төгрөг, нийт

17,491.2 мянган төгрөгийн орлого төвлөрч, үүнээс ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх үзлэг, хяналтын шатахууны зардлаас 31.1 мянган төгрөг зарцуулаагүй үлдэж төвлөрүүлсэн байна.

### **3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн**

Тайлант онд хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөр байхгүй.

### **3.5.5. Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл:**

Тайлант онд худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй.

## **4. АУДИТЫН ТАЙЛАН**

### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Шарын гол сумын Засаг даргын тамгын газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын шилэн дансны тухай хуультай холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Д.Ариунзаяа гүйцэтгэж, хяналтыг ахлах аудитор С.Батцэцэг, аудитын менежер У.Батсүрэн, газрын дарга, тэргүүлэх аудитор Ш.Мөнхбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

Шарын гол сумын Засаг даргын тамгын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 01 дүгээр сарын 31-ны өдрийн 03/34 тоот албан бичгээр ирүүлсэн.

### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2024 оны батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны батлагдсан төсөв 1,880,045.6 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 18,800.4 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Тайлант хугацаанд Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-д заасны дагуу батлагдсан төсвөөс нормын хувцас, зөөлөн эдлэлийн зардлыг 89.7 хувиар хэмнэж ажилласан байна.

### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг 4 шалгуур үзүүлэлтээр шалгахад шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд оруулбал зохих 144,700.5 мянган төгрөгийн 24 мэдээллийг байршуулаагүй нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5, 6.4.8 дахь заалттай нийцэхгүй байна.

##### Шийдвэрлэсэн нь:

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээ мэдээллийг хуулийн хугацаанд бүрэн байршуулж байх зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэсэн.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

#### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

##### 4.5.1 Завсрын аудитын талаар

Тус байгууллагын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд завсрын аудит хийгээгүй болно.

##### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны аудитаар 68,415.4 мянган төгрөгийн 3 зөвлөмж, 1 албан шаардлагын биелэлтийг ирүүлсэн 2024 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн 03/477 тоот албан бичиг, холбогдох баримтыг тулган шалгахад аудитын шийдвэрийн хэрэгжилт 100 хувь байна.

Хүснэгт 2 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	-	-	-	-	-
Албан шаардлага	1	-	1	-	100.0
Зөвлөмж	3	68,415.4	3	68,415.4	100.0
<b>Нийт дүн</b>	<b>3</b>	<b>68,415.4</b>	<b>3</b>	<b>68,415.4</b>	<b>100.0</b>

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй.

### 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 402,757.4 мянган төгрөгийн алдаа<sup>1</sup> илэрснийг аудитын явцад залрууллаа. Үүнд:

1. Санхүү байдлын тайланд 385,114.3 мянган төгрөгийн газрыг биет бус хөрөнгөөр бүртгээгүй нь УСНББОУС 17 “Үндсэн хөрөнгө”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3 дахь заалт, санхүүгийн тайлангийн аудитын “Үнэлгээ ба хуваарилалт”, “Ангилал” зэрэг батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул санхүүгийн байдлын тайланд биет бус хөрөнгөөр,

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

2. Мөнгөн гүйлгээний тайланд өмнөх оны төвлөрүүлэх шилжүүлэг 3,249.1 мянган төгрөгийг илүү тайлагнасан нь УСНББОУС 2 “Мөнгөн гүйлгээний тайлан”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3 дахь заалт, санхүүгийн тайлангийн аудитын “Иж бүрэн байх”, “Тасалбар болголт” зэрэг батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул мөнгөн гүйлгээний тайлангийн өмнөх он хэсэгт төвлөрүүлэх шилжүүлэг дүнг бууруулж тайлагнасан,
3. Анхан шатны баримтын бүрдэл дутуу, ажлын гүйцэтгэл гараагүй 10,000.0 мянган төгрөгийн урсгал засварыг тайлант үеийн зардлаар бүртгэсэн нь УСНББОУС 1 Санхүүгийн тайлагналын толилуулга, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3 дахь заалт, санхүүгийн тайлангийн аудитын “Үнэлгээ ба хуваарилалт”, “Ангилал” зэрэг батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул санхүүгийн байдлын тайланд авлагаар, үр дүнгийн тайлангийн зардлыг бууруулж тус тус залруулав

Мөн аудитаар нийт 4,394.0 мянган төгрөгийн зөрчил<sup>2</sup> илэрсэнд 1 албан шаардлага хүргүүлээ.

### 5.1 Төлбөрийн акт

Аудитаар төлбөрийн акт тогтоох зөрчилтэй асуудал илрээгүй болно.

### 5.2 Албан шаардлага

Тус байгууллагын санхүүгийн ажилтнуудад улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулалтай давхардуулан 4,394.0 мянган төгрөгийн балансын урамшуулал олгосон нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5.5-д “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3-т “Хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох”, Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтын 2.2-д “Төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгээр олгох мөнгөн урамшууллын дээд хэмжээ нь албан хаагчийн албан тушаалын сарын үндсэн цалингийн 50 хувиас хэтрэхгүй байна гэж” заасантай тус тус нийцээгүй тул зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлээ.

### 5.3 Зөвлөмж

Аудитаар зөвлөмж өгөх санхүүгийн тайлагналтай холбоотой зөрчилтэй асуудал илрээгүй болно.

Тайлангийн 4.4.1 дэх хэсэгт дурдсан Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчилд өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5<sup>3</sup>-д заасны дагуу ирүүлэх, биелэлтийг Дорхан-Уул аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 5 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

<sup>2</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/

<sup>3</sup> Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Мөнгөн гүйлгээний тайланд өмнөх оны төвлөрүүлэх шилжүүлгийг илүү тусгасан	1	3,249.1	-	-	1	3,249.1	1	3,249.1	-	-	-	-
Санхүү байдлын тайланд газрыг биет бус хөрөнгөөр бүртгээгүй	1	385,114.3			1	385,114.3	1	385,114.3				
Урсгал засварын ажлын гүйцэтгэл гараагүй байхад тайлант үеийн зардлаар бүртгэсэн	1	10,000.0			1	10,000.0	1	10,000.0				
<b>Дүн</b>	<b>3</b>	<b>398,363.4</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>3</b>	<b>398,363.4</b>	<b>3</b>	<b>398,363.4</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Үр дүнгийн урамшууллыг давхардуулан олгосон	1	4,394.0	-	-	1	4,394.0						
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>4,394.0</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>1</b>	<b>4,394.0</b>						

### Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
<b>Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил</b>								
Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст 24 мэдээллийг байршуулаагүй байна.	1	144,700.5	-	-	-	-	1	144,700.5
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>144,700.5</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>1</b>	<b>144,700.5</b>
<b>Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил</b>								
<b>Дүн</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>